

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ХОЁРДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны нэгдүгээр сарын 16-ны 14 цаг 06 минутад эхэлж, 16 цаг 49 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 43 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Дархан-Уул, Сэлэнгэ, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 12 дугаар сарын 02-19-ний өдрүүдэд Булган аймаг, Хөвсгөл аймаг, Өвөрхангай аймаг, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймаг, Баянхонгор аймаг, Сүхбаатар аймаг, Хэнтий аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Булган аймаг, Хөвсгөл аймаг, Өвөрхангай аймаг, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймаг, Баянхонгор аймаг, Сүхбаатар аймаг, Хэнтий аймагт 2014 оны 12 дугаар сарын 02-19-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 257 иргэн /Булган аймагт 43, Хөвсгөл аймагт 35, Өвөрхангай аймагт 26, Дархан-Уул аймагт 51, Сэлэнгэ аймагт 39, Баянхонгор аймагт 9, Сүхбаатар аймагт 12, Хэнтий аймагт 42/-ийг “Дэс түшмэлийн ангиллын</p>

		<p>төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 145 иргэн /Булган аймагт 13, Хөвсгөл аймагт 58, Өвөрхангай аймагт 6, Дархан-Уул аймагт 18, Сэлэнгэ аймагт 37, Баянхонгор аймагт 7, Сүхбаатар аймагт 2, Хэнтий аймагт 4/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 76 иргэн /Булган аймагт 18, Хөвсгөл аймагт 8, Өвөрхангай аймагт 6, Дархан-Уул аймагт 12, Сэлэнгэ аймагт 11, Баянхонгор аймагт 4, Сүхбаатар аймагт 6, Хэнтий аймагт 11/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 51 иргэн /Булган аймагт 6, Хөвсгөл аймагт 16, Өвөрхангай аймагт 3, Дархан-Уул аймагт 4, Сэлэнгэ аймагт 13, Баянхонгор аймагт 4, Сүхбаатар аймагт 2, Хэнтий аймагт 3/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх</p> <p>3. Энэхүү тогтоолын 17-32 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 127 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлд, Хөвсгөл аймаг дахь</p>
--	--	--

		<p>салбар зөвлөл /Г.Төмөрбаатар/-д, Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл /Ц.Ганболд/-д, Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл /Ч.Чүлтэмбат/-д, Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл /Ө.Сувдаа/-д, Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл /О.Тойвгоо/-д, Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөл /Ч.Лхамсүрэн/-д, Хэнтий аймаг дахь салбар зөвлөл /М.Болд/-д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Булган аймгийн Дашинчилэн сумын Нийгмийн даатгалын байцаагчаар ажиллаж байсан Ж.Батсууриас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Булган аймгийн Дашинчилэн сумын Нийгмийн даатгалын байцаагчаар ажиллаж байсан Ж.Батсууриас “Гомдол шийдвэрлэх тухай” Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 30 дугаар тогтоолыг эс зөвшөөрч Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.6-д заасныг удирдлага болгон:</p> <p>1. “Ажлаас халах тухай” Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Ц.Баярмаагийн 2014 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Б/34 дүгээр тушаалыг хууль зүйн үндэслэлгүй захиргааны акт гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж</p>

		<p>үзэх.</p> <p>2. “Ажлаас халах тухай” Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2014 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Б/34 дүгээр тушаалыг хүчингүйд тооцох.</p> <p>3. “Ажлаас халах тухай” Булган аймгийн Нийгмийн даатгалын дарга Ц.Баярмаагийн 2014 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Б/34 дүгээр тушаалыг хууль зүйн үндэслэлтэй байна гэж шийдвэрлэсэн “Гомдол шийдвэрлэх тухай” Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 30 дугаар тогтоолыг хүчингүйд тооцох.</p> <p>3. Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас гарсан тогтоолыг Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасны дагуу биелүүлж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар ажиллаж байсан Д.Тунгалагаас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар ажиллаж байсан Даваагийн Тунгалагаас Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Ганибалын “Албан тушаалд томилох тухай” 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/02 дугаар тушаалын өөрт холбогдох хэсгийг эс зөвшөөрч, Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд</p>

		<p>нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам"-ын "Нэг" дэх хэсгийн 3.4-ийн "в"-д заасныг удирдлага болгон:</p> <p>1. Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Ганибалын "Албан тушаалд томилох тухай" 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/02 дугаар тушаалыг хууль зүйн үндэслэлгүй байна гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.</p> <p>2. Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Ганибалын "Албан тушаалд томилох тухай" 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/02 дугаар тушаалын Д.Тунгалагт холбогдох хэсгийг хүчингүйд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>"Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авсан арга хэмжээ, ахиц дэвшил, үр дүн" сэдвээр Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн сонголт сонсож хэлэлцэх</p>	<p>Хуралдаанаар сонсголыг хэлэлцээд тус Салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулж байна хэмээгээд, цаашид Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, шударгаар явуулж, төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг дүрэм журмын дагуу тухай бүр, хугацаанд нь зохион байгуулахыг үүрэг болгож, зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг 2015 оны 6 дугаар сарын 15-ны дотор Төрийн албаны зөвлөлд тайлагнахыг Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлд даалгалаа.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

